

Richard Berengarten
Ричард Бэрэнгартэн

translation by Hadaa Sendoo
Орчуулагч Сэндоо Хадаа

Волта

...энэ мөчид үдшийн бүрэнхий нөмөрлөө...

Нарны сахиус, ягаахан хацарт, өдрийг бүтээгч, эзэмшигч
чамайг арьсанд минь хүрэхэд, эвэршин хатуурч,
нүдний өргөс өвдөж, бас бие минь чичирнэ
далай ба хотын дээгүүр сэтгэл татам алтан цөөрмөөр
чи урсана харин би сохорлоо.
Энд жагсан зогссон - миний мэддэг байшингууд,
гудамжууд - өөр хотын эзэмшил болсон ч
бүр мөсөн хувираагүй ээ чи.

Далайн эрэг даган бид алхана. Шөнөөр
загасчны завь далайд гарахаар бэлдэнэ,
моторын дуу хадан, тосон дэн завин дээр савлана
хотын гадуур амрагууд хөтөлцөн зугаална
залуу эрс эрх дураараа
эцэг эхчүүд, бас хүүхдүүд зайрмаг иднэ
хөгшид цайны газрын ширээний араас энэ тэрийг харна
үдшийн толгод аажуухан нүүнэ, дотны амьтад шиг

Намуун орой, туяа толгод ба далайн булангаар тархана,
гар чинь сая л намайг тэвэрлээ, санаандгүй тохиол мэт,
хажууд минь алхах бүсгүйг шүргэх би дуртай, тэр
өргөн ташаа, гунхсан жижигхэн алхаа,
уянгалаг хоолой, тэгшхэн мөр, гялалзсан хар үсээ намируулна,
хүрэл өнгөт зун, тэр чидун өнгөт борхон нүдээрээ инээмсэглэнэ.
би чамайг уумаар байна, гялтганах гэрэл мэт, дарс мэт, хөгжим шиг,
түүний согтолт чиний уусан хэдэн мянган жил.

Шаналсан хот, түүний нэр Эрх чөлөө
нүдэнд нь чиний сорви саарал сэвх мэт харагдана
өнөөг хүртэл гэрлээс гэрлийн хооронд хувирсаар
нүүрэн дээр нь үгс мэт дуу мэт уран тоглоно
энд эртний эрх далайн эргээр алхан
чиний туслах ба хамгаалагч болно
түүний дотны сурагчид ухаарлыг цуглуулна,
бас энхрий эрх чөлөөгөө, бүжигчин мэт мөрдөнө чи

Тэргэл шөнөөр, гэрэл мянга мянган жил гэрэлтүүлсээр
цээлхэн хоолойтой дуучин, энэ бүсгүй шиг хөөрхөн
үзэсгэлэнт царайг тань хайрлахгүй байж яаж чадна вэ

энэ хот бас энэ ард түмэн өөрчлөгдсөн
миний хүрсэн уран барималууд, бүтэн дэлхий мөн гэж үү?
хэрвээ би чиний иргэн биш бол, боол чинь больё.
цангавал чамайг бүхлээр чинь уугаад, бүх зовлонгын нүхийг бөглөө.
чиний гэрлээр, түүний эрх чөлөөгөөр.

Richard Berengarten
Ричард Бэрэнгартэн

translation by Hadaa Sendoo
Орчуулагч Сэндоо Хадаа

interLitQ.org